



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

Албан хаагчдын ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах дунд хугацааны
хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, тус яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Б.Батцэцэг)-д, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж, зориулалтын дагуу зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (П.Дэлгэрмаа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Жавхлан)-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ч.ЗОЛБАЯР

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны
12 дүгээр сарын 06-ны өдрийн А/129
дугаар тушаалын хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг.Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

1.1.Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, тус яамны “Хөдөлмөрийн дотоод журам” болон төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж нь энэхүү хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл болно.

1.2.Хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь харилцаа холбоо, мэдээллийн технологи, радио давтамж, сансар, өргөн нэвтрүүлэг, шуудан, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, кибер аюулгүй байдал, цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого, зохицуулалт, салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэн мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, салбарын инновацыг хөгжүүлэх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд ажиллаж байна.

Тус яам нь үндсэн бүтцийн 6 газар, бүтцийн нэгжийн 8 хэлтэстэй бөгөөд нийт 87 орон тоотой. Албан хаагчдын цалин хөлсийг Монгол Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмын дагуу тогтоосон хэмжээгээр тооцон олгож байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зарчим, хугацаа, зохион байгуулалт

2.1.Зорилго

Тус яамны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, хөдөлмөрийн харилцаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд ажиллуулах, нийгмийн асуудлыг судалгаанд үндэслэн нээлттэй, ил тод